

БНХАУ-ын “Цаг уурын хиймэл дагуулын бүтээгдэхүүний хэрэглээ” сэдэвт олон улсын цахим сургалтанд хамрагдсан товч тайлан

Нислэгийн цаг уурын төвийн мэдээлэл үйлчилгээний хэлтсийн Синоптик инженер ажилтай Б.Сарангэрэл миний бие 2020 оны 06 сарын 22-ноос 07 сарын 03-ны хооронд Хятадын цаг уурын байгууллагаас зохион байгуулсан “Цаг уурын хиймэл дагуулын бүтээгдэхүүний хэрэглээ” сэдэвт олон улсын цахим сургалтанд хамрагдсан.

Энэхүү олон улсын сургалтын зорилго нь цаг агаарын урьдчилсан мэдээнд хиймэл дагуулын бүтээгдэхүүнийг ашиглах чадварт, цаг уурын хиймэл дагуулын сүүлийн үеийн шинэчлэгдсэн бүтээгдэхүүнийг судлах, суралцахад оршино.

Сургалтын агуулга:

- FY хиймэл дагуулын танилцуулга, бүтээгдэхүүний хэрэглээ
- Сансрын Цаг уурын үйлчилгээний талаарх Дэлхийн цаг уурын байгууллагын зөвлөмж, зөвлөгөө Байран хиймэл дагуулын одоогийн болон ирээдүйн бүтээгдэхүүнүүд: хиймэл дагуулын үүлний зураг, сансрын цаг уурын ажиглалт гэх мэт. Сансрын цаг уурын тухай товч танилцуулга, сансрын цаг уурын ажиглалтын онцлог шинж, агуулга.

Хиймэл дагуулын мэдээний хүлээн авалт, боловсруулалт

- Цаг уурын хиймэл дагуулын мэдээ ашиглан урьдчилсан мэдээнд дүн шинжилгээ хийх, урьдчилан мэдээлэх Үүлний хөдөлгөөнт салхины бүтээгдэхүүн

Хиймэл дагуулын бүтээгдэхүүний хэрэглээний программ: SWAP, SMART Хятадын цаг уурын байгууллага, сургалтын төвтэй товч танилцах

Багш нар: Дэлхийн цаг уурын байгууллагын албан хаагч, Хятадын цаг уурын хиймэл дагуулын үндэсний төвийн болон Хятадын цаг уурын байгууллагын сургалтын төвийн доктор багш нар оролцсон.

Сургалтын бүх үйл явц цахим хэлбэрээр явагдсан.

Сургалтаар Цаг уурын хиймэл дагуулын тухай ерөнхий танилцуулга хийгдсэн.

Үүнд: Бидний ашиглаж буй FY2 хиймэл дагуул нь FY4 хиймэл дагуул нь 14 сувагтай бөгөөд үүлний оптик зузаан, услагийн хэмжээ, аерозолийн оптик зузааны манан зэрэг бүтээгдэхүүнийг гаргадаг. FY4 болон HIMAWARI-8/9 хиймэл дагуулын бүтээгдэхүүнийг цаг уурын урьдчилсан мэдээнд ашиглах аргачлал мөн хиймэл дагуулын мэдээг боловсруулах мөн олон улсын нислэгийн цаг уурын үйлчилгээнд шинээр нэвтэрч буй сансрын цаг уурын тухай ерөнхий ойлголтыг авч, түүний үзэгдлийг мэдээллэх арга аргачлалын тухай судалж суралцсан.

Уг сургалтанд 87 орны 599 цаг уурчид, олон улсын нисэх буудлуудын болон цаг уурын синоптик инженерүүд, IT инженерүүд хамрагдсан.

Дүгнэлт: Энэ сургалт нь хиймэл дагуулын мэдээ ашиглан цаг агаарын нөхцөл байдлыг шинжлэх, цаг агаарын үзэгдэл, параметруудийг урьдчилан таамаглах, цаг агаарын аюултай үзэгдлийг урьдчилан мэдээллэх, цаг агаарын үзэгдлийн аргачлалыг ашиглах, ур чадварыг дээшлүүлэх, сайжруулахад мөн сансрын цаг уурын тухай ойлголт, мэдээллийг авсан. FY хиймэл дагуулын мэдээг SWAP, SMART программ ашиглан нэмэлт боловсруулалт хийх боломжтой. Одоо манай улс FY2 хиймэл дагуулын мэдээг ашиглаж байгаа бөгөөд цаашид Хятадын цаг уурын байгууллагат хүсэлт тавьснаар FY4 хиймэл дагуулын бүтээгдэхүүнийг ашиглах бүрэн боломжтой.

Тайлан бичсэн:

НЦУТ-ийн Синоптик инженер:



Б.Сарангэрэл